


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/17.

Мандалговь

[] Ажлын хэсэг байгуулах тухай []

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" заалт, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолын "Монгол мал" үндэсний хөтөлбөр батлах тухай хавсралтын 3.4.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бус нутгийг шинэчлэн тогтоох, бэлчээрийн хэв шинж тодорхойлох, отрын бэлчээрийн хилийн заагийг баталгаажуулж, газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах, орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бэлчээр ашиглалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)


Б.Хорлоо (Өлзийт сумын Засаг даргын үүргийг тур орлон гүйцэтгэгч)

С.Амарсанаа (Сайхан-Овоо сумын Засаг дарга)

Б.Лхагвамандал (Эрдэнэдалай сумын Засаг дарга)

М.Батсүх (Дэлгэрхангай сумын Засаг дарга)

2. Сумдын орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бус нутгийн бэлчээрийн судалгааны дүнг нэгтгэн, Иргэдийн төлөөлөгчдүүн хурлын тэргүүлэгчдүүн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

481210320